



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

2024 оны 12 сарын 26 өдөр

Дугаар E/16

Төрийн срдон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Элчин сайдыг томилох
асуудлаар зөвшилцөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Наваан-Юндэнгийн Оюундэрийг томилох асуудлыг зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Холбогдох материалыг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.12.26 № 35-1/174
таний —-ны № —-т

Санал өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бархасын Доржийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Наваан-Юндэнгийн Оюундэрийг томилуулах тухай саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу өргөн мэдүүлж байна

Холбогдох материалыг хавсаргав.



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС**

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 46 дугаар тэмдэглэлд:

“40.1.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдыг эгүүлэн татах, томилох саналын тухай

ШИЙДВЭРЛЭССЭН нь: Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бархасын Доржийг эгүүлэн татах, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдыар Наваан-Юндэнгийн Оюундарийг томилуулах саналыг дэмжиж, энэ тухай саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад
суугаа Элчин сайдыг эгүүлэн татах, томилох
саналын тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бархасын Доржийг эгүүлэн татах, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Наваан-Юндэнгийн Оюундарийг томилох саналыг танилцуулж байна.

Эгүүлэн татагдаж буй Элчин сайд Б.Доржийн томилолтын хугацаа нь дууссан болно.

Элчин сайд нь Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд суугаа болон хавсрان суугаа улс, олон улсын байгууллагадаа Монгол Улсыг төлөөлөн ажиллаж, эрх, ашиг сонирхлыг нь хамгаалах, харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсын хөгжлийн зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах судалгааг хийж, төр, засгийн байгууллагыг мэдээллээр хангах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, хоёр болон олон талын харилцааны асуудлаар хэлэлцээ хийх, холбогдох шийдвэрийн дагуу гэрээ хэлэлцээр байгуулах, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг олон улсын эрх зүй, суугаа орны хууль тогтоомжийн дагуу хамгаалж ажилладгаас гадна тэргүүлж буй Элчин сайдын яамныхаа үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байдаг.

Элчин сайдаар томилон ажиллуулахаар нэр дэвшүүлж буй Н.Оюундарь нь төрийн алба, олон улсын байгууллагад олон жил ажилласан, дипломат албанад ажилласан туршлагатай, мэргэжлийн өндөр ур чадвартай, удирдах ажлын дадлага туршлагатай, Орос, Англи, Герман, Хятад хэлний мэдлэгтэй, төрийн болон дипломат албаны хууль тогтоомжийн шалгуурыг хангасан, төрийн тусгай албанад ажиллах бүрэн боломжтой болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗӨВШӨӨРӨВ. ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Б.БАТЦЭЦЭГ

ТАНИЛЦУУЛГА

1. Наваан-Юндэнгийн Оюундариийг Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдар томилуулхаар танилцуулж байна.

2. 1973 онд Улаанбаатар хотод төрсөн.

3. 51 настай

4. Эмэгтэй

5. Гэр бүлийн байдал: Нөхөр, 2 хүүхэдтэй

6. Хэзээ, хаана ямар сургууль, дамжаа төгссөн, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:

1991 онд Политехникийн их сургуулийг Гадаадын инженерийн бэлтгэл, 1991-1995 онд "Сэргүүлэг" дээд сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгсөж, 1997-1998 онд Нидерландын Хаант Улсын Маастрихтын их сургуульд бизнесийн удирдлагын магистр зэрэг хамгаалсан. Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд 2016-2020 онд "Эрх зүйч" мэргэжлээр сурч төгссөн. Бизнесийн удирдлага, эрх зүйч мэргэжилтэй. Орос, Англи, Герман, Хятад хэлний мэдлэгтэй.

7. Ажилласан байдал:

1995 онд Монголын Үндэсний Бүтээмжийн Төвд зөвлөх, 1996 онд Монголын Бизнесийн хөгжлийн агентлагт Европын Холбооны ТАСИС хөтөлбөрт зөвлөх, 1998 онд НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн агентлагийн өөрчлөн байгуулалтын төсөлд зөвлөх, 1997 оноос Баатарван Наваан-Юндэн сан ТББ-ийн тэргүүн, 1999 онд Дэлхийн Банкны Олон улсын санхүүгийн корпорациын Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төсөлд зөвлөх, 2004-2006 онд Байгаль орчны яамны хамтын ажиллагааны хэлтсийн дарга, НҮБ-ын "Биологийн төрөл зүйл"-ийн конвенцын талуудын бага хурлын дэд дарга, 2004-2007 оны Байгаль орчны яамны Стратеги төлөвлөлт, бодлого зохицуулалтын газрын дарга, 2008-2012 онд НИТХ-ын төлөөлөгч, 2009-2012 онд Бээжин хот дахь Улаанбаатар хотын төлөөлөгч, 2012-2014 онд "Блюмон групп"-ын зөвлөх, 2014-2015 онд Гадаад харилцааны Дэд сайд, 2016-2020 онд УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга, 2020-2023 онд "Блюмон групп"-ын зөвлөх, 2023 оноос одоог хүртэл МАН-ын ЕНБД-ын зөвлөхөөр ажиллаж байна.

8. Ажилласан хугацаа (жилээр): Төрийн албанад 16 жил

Дипломат албанад 1 жил

9. Энэ иргэнийг тухайн албан тушаалд томилуулах (чөлөөлүүлэх) үндэслэл:

Мэргэжлийн ур чадвар, удирдах ажлын дадлага туршилага, гадаад хэлний мэдлэгийг харгалzan энэхүү албыг хаших бүрэн боломжтой гэж үзэж байна.

10. Тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан мэргэшлийн шалгалтын дүн

Гадаад харилцааны сайдын саналаар

11. Энэ асуудлыг шийдвэрлүүлэх (хэний санал ирсэн)-ээр бэлтгэсэн

12. Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт

Хянасан: Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтын газар /ТЗХНУЗБГ/-ын захирал

Боловсруулсан: ТЗХНУЗБХ-ын хоёрдугаар нарийн бичгийн дарга

Д.Булган
Т.Эрдэнийнчулгуу

13. Албан тушаалд томилох үед өгсөн үүрэг, зөвлөмж

2024 оны 12 дугаар сарын "13"-ны өдөр



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сүүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: <http://iaac.mn>

2024. 12. 26 № 03/21250.
танай —ны № —т

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР
ТАНАА

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилогдоо нэр дэвшсэн Наваан-Юндэнгийн Оюундариин хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн тус газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс хянахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

3.БААСАННЯМ



УХААНЫ 5120020